



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 4/93

Хэрлэн сум

Аймгийн хэмжээнд авто үйлчилгээний чиглэлээр
үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж,
байгууллагад авах арга хэмжээний тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Авто тээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 76 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад авто үйлчилгээний ангиллын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгох, тэдгээрийн ажилтнуудын мэргэжил, ур чадварыг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулж хэрэгжүүлэн ажиллах, авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын дагаж мөрдөх хууль, тогтоомж дүрэм журам, стандартын мөрдөлтийг хангуулах, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх аюултай хог хаягдалд хяналт тавьж, тэдгээрийн үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллах ажлын ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Чогсомжав	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Э.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ч.Пүрэвдорж	Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга
	Б.Ганбат	Автотээврийн төвийн дарга
	Б.Сүнгээ	Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

2. Захирамжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээний удирдамж боловсруулан хэрэгжүүлж хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



НБГАУНБЭМБЭ\Захирамж 2018.doc

011.07